



## Иосеф Шоронд Орсон нь

**ИВЭЭЛ** Их Эзэн биднийг мэддэг бөгөөд бидэнд санаа тавьдаг.

### Унших Зүйл

Эхлэл 39:1-6, 17-23; 40:1-23; *Эцэг Өвгөд ба Зөнчид*, х. 213-219.

### Цээжлэх Ишлэл

"Их Эзэн Есүс Христийн хайраас биднийг юу ч салгаж үл чадна" (Ром 8:38, 39).

### Зорилго

#### Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Заримдаа муу явдал тохиолддог ч Бурхан биднийг хайрласаар байдаг гэдгийг **мэдэх** болно.

Муу цаг үед ч гэсэн Бурханаар хайрлагдсан гэдгээ **мэдрэх** болно.

Бурхан руу асуудалтайгаа **хамт ирдэг** болно.

### Гол Санаа



Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.

## Хичээлд Бэлтгэх нь

### Библийн Хичээлийн Товчлол

Фараоны хүмүүсийн нэг болох Потифар Иосефыг худалдан авчээ. Удалгүй Потифарын гэрийн бүх л асуудлыг хариуцах болов. Потифарын эхнэр Иосефыг худал гүтгэснээр Иосеф шоронд орно. Их Эзэн Иосефын хичээл чармайлтыг ивээж, шоронгийн бүх л хүмүүсийн асуудлыг Иосеф хариуцдаг болжээ.

Хааны дарс аягалагч болон талхчин хоёр зүүднийхээ учрыг тайлж чадахгүй байхад нь Их Эзэн Иосефт хэлж, Иосеф тэдэнд зүүднийх нь учрыг

хэлж өгчээ. Гурван өдрийн дотор дарс аягалагч ажилдаа эргэн орох ба талхчин цаазаар авахуулна. Иосеф дарс аягалагчид өөрийг нь шоронгоос гаргахыг хаанаас асуугаарай гэж хэлсэн боловч дарс аягалагч Иосефын тухай мартжээ.

Иосеф тэвчээртэйгээр Их Эзэнд итгэж байв. Тэр тууштай бөгөөд сайн ажилладаг. Тэр чадах бүхнээрээ хүмүүст тусалдаг. Их Эзэн Иосефыг шоронд байхад асарч байсан бөгөөд түүнийг хамгаалж байжээ.

# АРВАН НЭГ

Хичээлийн Төлөвлөгөө				
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ	
<b>Мэндчилгээ</b>	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух		
<b>1</b>	<b>Бэлтгэх Ажил</b>	10 минут	<i>А. Сайхан болон Муухай Цаг Үе</i> <i>Б. Номын Тэнцвэр</i>	сайн ба муу үеийг илтгэсэн зураг номууд
<b>*</b>	<b>Залбирал ба Магтаал*</b>	10 минут	113-р хуудсыг үз. <b>*Залбирал ба Магтаал-ыг</b> хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
<b>2</b>	<b>Библийн Хичээл</b>	20 минут	Түүхтэй Танилцах	байхгүй
			Библи Судлал	Библи
			Цээжлэх Ишлэл	Библи
<b>3</b>	<b>Хичээлээ Заах</b>	15 минут	<i>Муу Зүйл Үггүй Жүжиг</i>	байхгүй
<b>4</b>	<b>Хичээлээ Хуваалцах нь</b>	15 минут	<i>Баяртай Гунигтай Зүрх</i>	баяртай болон гунигтай зүрхний загвар (147-р хуудас), цаас, цавуу, модон савх

## Энэ бол ивээлийн тухай хичээл

Их Эзэн бидэнд хайртай учраас бид сайн муу ямар ч нөхцөлд байсан Их Эзэн бидэнд санаа тавина гэдэгт итгэх хэрэгтэй. Тэр бидэнд тэвчээртэй бас тууштай байхад минь үргэлж тусална. Хэдий муу зүйл тохиолдсон ч Их Эзэн биднийг харсаар байдаг ба хайрласаар байдаг.

## Багшийн Баяжуулалт

"Иосефт тохиолдсон бүхэн нь шууд утгаараа гайхамшиг тохиолдсон явдал биш юм. Харин түүний нинжин сэтгэл, халамж хайр, хүч чадал нь ивээлийг хүртэхэд тусалсан юм". (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 214).

"Потифар эхнэртээ итгэснээс болоод Иосефын эсрэг залуу Еврейгийн

амьдрал сүйрч болох байлаа:...

Эзнийхээ гэрийн хамгаалалтын төлөө ажиллаж байсан тэрээр хуурамч гүтгэлэгт орон хаягджээ". (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 218).

Та ямар нэгэн зүйлд гүтгэгдэж байсан уу? Таны зан чанарыг мэддэг учраас бусад хүмүүс таныг буруугүй гэдгийг мэдэж байсан уу?

## Өрөөний Зохион Байгуулалт

Египетийн хиймэл шүтээн, шүүр, ваар, ширээ, сандал зэргийг ашиглан Египет гэр тайзаа зас. Шорон хийхийн тулд 8-р хичээлд хэрэглэсэн том даавууг ашигла. Тайзны хөшиг болгон том хар даавуу ашигла. Эсвэл сандал ашиглан нэг буланд шорон хэлбэртэй харагдахаар засаж болно.

## Заах Хичээл

### Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

### Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

#### А. Сайхан болон Муухай Цаг Үе

##### Хэрэгтэй зүйлс:

- сайхан цаг болон муухай цаг үеийг илтгэсэн зурагнууд

Төрсөн өдрийн баяр, найз нартайгаа тоглох, усанд сэлэх, гэр бүлийн зугаалга зэрэг сайн цагийг илэрхийлсэн зурагнууд, шуурга, эвдэрсэн тоглоом, өвдөх, нурсан байшин зэрэг муу цагийг илэрхийлсэн зурагнуудыг бэлд.

Хэлэх: **Энэ зурагнуудыг аваад хүн бүрийн нүдэнд үзэгдэхээр газар тавих хүүхдүүд надад хэрэгтэй байна. Тэгээд би та нараас энэ цаг үеүдэд Их Эзэн бидэнтэй хамт байсан эсэхийг асууна. Хэрвээ хариулт чинь тийм гэвэл босоорой. Хариулт чинь үгүй гэсэн байвал суудалдаа сууж байгаарай.**

##### Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Их Эзэн бидэнтэй цаг үргэлж хамт байдаг уу? Хэцүү цаг үед ч гэсэн үү? Тийм ээ, цаг үе хэцүү байхад ч Есүс бидэнтэй үргэлж хамт байдаг бөгөөд бидэнд санаа тавьсаар байдаг.**

Өнөөдрийн үзэх Библийн түүхэнд Иосефын тухай гарна. Иосеф аавтайгаа байхдаа жаргалтай байсан, түүнтэй Бурхан үргэлж хамт байсан. Иосефт ах нар нь муу хандах үед ч Бурхан түүнтэй хамт байсан юм. Энэ долоо хоногийн хичээлээс бид Иосефт тохиолсон сайхан болон муухай үеүдийг бүр сайн мэдэх болно. Энэ бүх цаг үеүдэд Их Эзэн Иосефтой хамт байгаа гэдгийг тэр мэдэж байсан ба Их Эзэнд үргэлж итгэж байсан юм. Хичээлийн гол утга санаа:



**Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.**

Намайг дагаад хэлээрэй.

#### Б. Номын Тэнцвэр

##### Хэрэгтэй зүйлс:

- номнууд

Хүүхдүүд нэг цэгээс нөгөө цэг хүртэл явахдаа толгойн дээрээ ном тогтооно. Хэрвээ ном нь унавал тэд эхнээсээ явах болно.

##### Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Явж байхдаа толгой**

дээрээ ном тавих нь хэцүү байна уу? Амархан байна уу? Та нарт ямар байсан бэ? Заримдаа зарим нэгэн зүйл хэцүү байдаг ч заримдаа амархан байдаг юм. Хэрвээ ямар нэгэн зүйл амархан байвал бид түүнийг хийхэд дуртай байдаг. Харин хэцүү байвал бид түүнийг хийх тийм ч дуртай байдаггүй шүү дээ.

Өнөөдрийн үзэх Библийн түүх нь Иосефын тухай юм. Энэ долоо хоногт бид Иосефт тохиолдсон сайн болон муу зүйлийн тухай илүү сайн мэдэх болно. Цаг үргэлж Их Эзэн өөртэй нь хамт байгаа гэдгийг Иосеф мэдэж байсан бөгөөд Түүнд итгэсэн хэвээрээ байлаа. Хичээлийн гол утга санаа:



Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.

Намайг дагаад хэлээрэй.

## ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



### Нохорлол

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

### Санал Болгох Дуунууд

"Тэр чамд санаа тавьдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 91*)

"Есүс намайг харж байгаа" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 109*)

"Их Эзэн хамгийн сайн нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 88*)

"Унтаж тоглож байхад минь Их Эзэн харж л байдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 122*)

"Халамттай хэн нэгэн" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 170*)

### Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс нэгэн түүх уншиж өгөөрэй. Асуух:

**Өнөөдрийн түүхэнд Их Эзэн хүмүүст хайртайгаа хэрхэн харуулж вэ?**

### Хандив

Хэлэх: Өнөөдөр бид өргөлөө авчирснаараа Их Эзэнийг хүндэлж байдаг бөгөөд өргөлөөр минь дамжуулан бусад хүмүүс ямар ч үед Их Эзэн тэдэнтэй хамт байдаг гэдгийг мэдэх болно.

### Залбирал

"Есүс чамайг халамжилдаг" гэсэн залбирлын дуу дуул. (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 92*)

\* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

**Түүхтэй Танилцах**

*Хүүхдүүдийг тус бүр Иосеф, цай аягалагч, талхчин, шоронгийн хуяг болох нэг нэг том хүнтэй дөрвөн бүлэгт хуваа.*

<b>Та:</b>	<b>Хүүхдүүд үсрээд хэлэх:</b>
<b>Иосеф</b>	Би Их Эзэнд итгэдэг.
<b>Талхчин</b>	Би талхаа шалгах ёстой.
<b>Дарс аягалагч</b>	Энэ шүүс сайхан амттай юм.
<b>Шоронгийн хуяг</b>	Иосеф бол сайн залуу.

*Хүүхдүүдийг үсрээд хэлэх үгийг нь бэлдүүл. Хэлэх: **Намайг "шорон" гэж хэлэхэд та нар бүгд бие биенийхээ гараас бариарай.** (Тохойтойгоо зэрэгцүүлж нударгаа тавина). **Одоо давтацгаая.** (Хугацаа олгоно). **Түүхийг ярьж байхад өөр өөрийн дүрээ санаж байгаарай.***

**Түүхийг уншиж эсвэл ярьж өгөх**

**Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] буруу зүйл хийгээгүй гэдгээ мэдэж байлаа. Тэр **шоронд** [бугуйгаа барих] орох ёсгүйгээ ч мэдэж байв. Тэр мөн нэг чухал зүйл мэдэж байжээ. Түүнтэй хамт Их Эзэн байгаа бөгөөд **шоронд** [бугуйгаа барих] ороход нь хүртэл хамт байна гэдгийг мэдэж байсан.

"Нааш ирж оройн зоог барихад тусал" гэж **хуяг** [Иосеф бол сайн хүн] **Иосефт** [Би Их Эзэнд итгэдэг] хэлэхэд **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] зөвшөөрлөө.

Бүх хүмүүсийг хоолоо идэж дуусахад нь "Цэвэрлэгээнд туслаач" гэж **хуяг** [Иосеф бол сайн хүн] **Иосефт** [Би Их Эзэнд итгэдэг] хэлэхэд **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] хийжээ.

Өдөр бүр **хуяг** [Иосеф бол сайн хүн] **Иосефт** [Би Их Эзэнд итгэдэг] үүрэг өгч **Иосеф** [Би Их Эзэнд

*итгэдэг]* ямар ч гомдолгүйгээр бүгдийг хийдэг байв. Тэр үргэлж сайныг хийхийг хүсдэг байж. Удаан хугацааны дараа **хуяг** [Иосеф бол сайн хүн] **Иосефыг** [Би Их Эзэнд итгэдэг] **шоронгийн** [бугуйгаа барих] бүх л асуудлыг хариуцуулуулахаар үүрэг өгчээ.

Нэгэн өглөө **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] босоод **шоронд** [бугуйгаа барих] байгаа хоёр хүн ихэд гунигтай байхыг харав. Нэг хоригдол нь хааны **дарс аягалагч** [Энэ шүүс амттай байна] нөгөө нь **талхчин**. [Би талхаа шалгах ёстой] Гэвч хаан тэдэнд уурлан **шоронд** [бугуйгаа барих] хийчихжээ.

"Юу болоов?" гэж **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] асуухад **дарс аягалагч**, [Энэ шүүс амттай байна] **талхчин** [Би талхаа шалгах ёстой] хоёр "Өнгөрсөн шөнө бид их сонин зүүд зүүдэллээ. Энд байгаа хэн ч бидэнд зүүдний маань утгыг хэлж чадахгүй байна" гэхэд **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] "Энэ зүүдийг чинь зөвхөн Их Эзэн л тайлж чадна. Тэгээд юу зүүдлэсэн юм бэ?" гэв

"Би гурван төрлийн дарс харж байна гэнэ. Дарсан дээр усан үзэм байхаар нь усан үзэмний шүүсийг хаанд аягалаж өгч байна гэж зүүдэллээ" хэмээн **дарс аягалагч** [Энэ шүүс амттай байна] хэлэхэд **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] "Зүүдийг чинь тайлахад Их Эзэн надад туслах болно. Гурван өдрийн дотор чи суллагдаж хуучин ажилдаа очих юм байна" гэжээ.

**Дарс аягалагч** [Энэ шүүс амттай байна] ихэд баярлан томоос том инээмсэглэжээ.

**Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] түүнд "Чи суллагдаж гараад хаанд миний тухай хэл. Би ямар ч буруу зүйл

хийгээгүй шоронд суух ёсгүй гэдгийг минь хэл" гэжээ.

Тэгээд **талхчин** [Би талхаа шалгах ёстой] **Иосефт** [Би Их Эзэнд итгэдэг] "Би толгой дээр минь гурван талхны сагс байна, тэгээд хамгийн дээд талын сагсанд нь хаанд өгөх амттан байсан боловч шувуу идчихлээ гэж зүүдэллээ" гэв.

**Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] Их Эзэнд чимээгүйхэн залбираад "Зүүдийг чинь тайлж өгье. Гурван өдрийн дотор хаан чамайг шийтгэж чи үхэх болно" гэв. Гурван өдрийн дотор хааны төрсөн өдөр болж том найр хийжээ. Хаан **шорон** луу [бугуйгаа барих] хүн явуулж **дарс аягалагч** [Энэ шүүс амттай байна] болон **талхчин** [Би талхаа шалгах ёстой] хоёрыг авчруулахаар явуулав. Хаан яг **Иосефын** [Би Их Эзэнд итгэдэг] хэлснээр **дарс аягалагчийг** [Энэ шүүс амттай байна] ажилд нь оруулж **талхчинг** [Би талхаа шалгах ёстой] шийтгэх болов.

**Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] **дарс аягалагчийг** [Энэ шүүс амттай байна] хүлээсээр... Тэр түүнийг өөрийнх нь тухай хаанд хэлээсэй гэж хүссэн билээ. **Дарс аягалагч** [Энэ шүүс амттай байна] тэр үед ажилдаа түүртэн **Иосефын** [Би Их Эзэнд итгэдэг] тухай мартчихжээ.

Гэвч **Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] **шоронгийнхоо** [бугуйгаа барих] ажлыг улам л сайн хийсээр ...

**Иосеф** [Би Их Эзэнд итгэдэг] **шоронд** [бугуйгаа барих] байсан хэдий ч их тэвчээртэй байсан бөгөөд Их Эзэн өөрийг нь хайрлаж байгааг мэддэг бас Их Эзэнд итгэж найдаж байлаа.

### Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Муу зүйл тохиолдсоор**

**байхад Иосеф яагаад Их Эзэнд итгэж байсан бэ? Та нар яг Иосеф шиг Их Эзэнд итгэж чадна гэж бодож байна уу?**

**Заримдаа Их Эзэний хүмүүст муу зүйл тохиолддог ч энэ нь Их Эзэн биднийг хайрлахаа больж харж хандахаа зогсоосон гэсэн үг биш юм. Их Эзэн үргэлж бидэнтэй хамт байдаг. Гол санааг санаж байна уу?**



**Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.**

Намайг дагаад хэлээрэй.

### Библи Судлал

Библиэ нээгээд Эхлэл 39:1-6, 17-23 болон 40:1-23-г гарган **"Өнөөдрийн бидний үзсэн түүх Библийн маань энэ хэсэгт байна"** гэж хэлээд ишлэлийг чангаар унш.

Асуух: **Иосеф хэний төлөө ажиллаж байсан бэ? Иосеф чухал ажил хийж байсан уу? Иосеф яагаад шоронд орсон бэ? Тэр тэнд ямар ажил хийж байсан бэ?**

**Хэн зүүд зүүдэлсэн бэ? Тэдний зүүд ямар утгатай байсныг хэн хэлж чадах байсан бэ? (Их Эзэний тусламжтайгаар Иосеф). Дарс аягалагчийг өөрийгөө суллуулах тухай хэнд хэлээсэй гэж Иосеф хүссэн бэ? Тэгээд юу болсон бэ? Их Эзэн түүнтэй хамт байгааг Иосеф мэдэрсэн үү?**

**Муу цаг үед ч гэсэн Их Эзэн чамтай байгаа гэдгийг та нар мэдэрдэг үү?**

Санацгаая...



**Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.**

Намайг дагаад хэлээрэй.

**Хэрэгтэй зүйлс:**

Библи

### Цээжлэх Ишлэл

#### Хэрэгтэй зүйлс:

□ Библи

Библиэ нээгээд Ром 8:38,39-г гарган хэлэх: **"Өнөөдөр бид цээжлэх ишлэлээ Бурханы үг болох Библийн энэ хэсэгт байна"** гээд ишлэлийг чангаар унш. **"Их Эзэн Есүс Христийн хайраас биднийг юу ч салгаж үл чадна"**

**Асуух: Салгах гэдэг үг ямар утгатай вэ? Салгах гэдэг нь ямар нэгэн зүйлээс ямар нэгэн юмыг нь авахыг хэлж байгаа юу? Хэрвээ чи салгаж чадахгүй байвал энэ нь маш сайн наалдсан гэсэн үг юм. Энэ бол Их Эзэний хайр шүү дээ.**

**Биднийг хаана ч байсан, бидэнд юу ч тохиолдсон Их Эзэний хайраас биднийг юу ч салгаж чадахгүй. Энэ бол боломжгүй зүйл юм. Тэр үргэлж бидэнтэй хамт байдаг, Тэр үргэлж биднийг хайрладаг.**

**Цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг хүүхдүүдэд зааж өг.**



**Их Эзэн Есүс Христийн**

Дээшээ заа.



**хайраас**

Цээжин дээрээ гараа зөрүүлж тавих.




**биднийг**

Өөрийгөө заах.



**юу ч**

Долоовор хуруугаа үгүй гэсэн маягтай хөдөлгөх.



**салгаж үл чадна.**

Гараа нийлүүлж хоёр тийш нь салгах.



**Ром 8:38,39**

Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## 3

### Хичээлээ Заах

#### Муу Зүйл Үггүй Жүжиг

**Хэлэх: Өвдөгөө шалбалах, унах гэх зэрэг муу зүйл тохиолдож байгаа дүрийг хэн надад жүжиглэж үзүүлэх вэ? Тэгээд түүнийг чинь бид таах болно.**

Хүүхэд бүр ярихгүйгээр ямар нэгэн зүйл жүжиглэж үзүүлнэ. Хэрвээ тэдэнд бодоход нь туслалцаа хэрэгтэй бол та дараах үйлдлүүдийг санал болгож чихэнд нь шивнэж өгөөрэй. Хөлийнхөө хурууг юманд цохих, толгойгоо ширээнд мөргөх, мууранд маажуулах, хамар битүүрэх эсвэл хоолой сөөх, дугуйтайгаа унах, дэлгүүрт төөрөх гэх мэт.

#### Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Зарим зүйл тийм ч сайхан байдаггүй шүү дээ, үгүй гэж үү? Муу зүйл тохиолдох үед чинь хэн чамд тусалж чадах вэ? (Аав, ээж, найзууд гэх мэт).**

**Чамайг бэртэх үед аав ээж чинь чамайг хайрласаар л байдаг уу? Мэдээж тэд хайртай. Чамайг бэртэхэд аав ээж чинь гунигтай байдаг уу? Тэд чамд муу зүйл учрахыг хүсдэггүй, гэвч заримдаа муу зүйл тохиолддог шүү дээ. Аав ээж чинь чамд хайртай учраас чамайг бэртэх үед туслахыг хичээдэг.**

**Чамайг сайн болгохын тулд тэд яаж туслахыг хичээдэг вэ? Чамайг**



бэртэх үед Бурхан ч гунигтай байдаг. Бурхан ч чамд муу зүйл учрахыг хүсдэггүй, гэхдээ заримдаа муу зүйл тохиолдож байдаг. Чамд муу зүйл тохиолдох үед Бурхан чамтай хамт байгаа гэдгийг мэдээсэй гэж Тэр хүсэж байдаг. Тэр чамайг хэзээ ч орхихгүй. Тэр чамайг одоо ч гэсэн хайрлаж халамжилж байна. Үүний тухай бодоорой:

Бурхан намайг баяртай байхад хайрлаж л байдаг

Намайг гунигтай байхад хайрлаж л байдаг.

Бурхан бүх зүйл муу болсон ч

намайг хайрлаж байдаг.

Бүх зүйл сайн байхад ч хайрлаж байдаг.

Бүгдээрээ энэ шүлгээ дахин давтацгаая. Шүлгийг дөрөв эсвэл таван удаа давтаарай. Хүүхдүүдээс ямар нэгэн үйл хөдлөл хийхийг нь асуу. Хэлэх: **Гол санаагаа хамтдаа хэлцгээе.**



Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.

Намайг дагаад хэлээрэй.

## 4

### Хичээлээ Хуваалцах нь

#### Баяртай ба Гунигтай Зүрх

Юуны өмнө, хүүхэд бүрт баяртай болон гунигтай зүрхийг хувилж өг (147-р хуудас) хүүхэд бүр (2 зүрхтэй байх ёстой).

Нэг зүрхэн хэлбэртэй цаасан дээр хүүхдүүд "Баяртай үед Бурхан надад хайртай байдаг" гэдэг үг бичиж баяртай нүүр зуруул. Харин нөгөө цаасан дээр нь гунигтай нүүр зураад "Гунигтай үед ч Бурхан надад хайртай байдаг" гэж бичүүлээрэй. Хүүхдүүд зургийг будаад хайчилж авч болно. Хоёр зурсан цаасаа хооронд нь нааж дунд нь иш хийвэл хүүхдүүд бариад сууж болох юм.

#### Бататгах нь

Хэлэх: **Баяртай үед Бурхан чамайг хайрладаг уу? Тийм ээ. Надад баяртай царайгаа харуулаач.**

Гунигтай үед Бурхан чамд хайртай байдаг уу? Тийм ээ. Гунигтай нүүрээ хар. **Их Эзэн чамайг цаг үргэлж хайрлаж байдаг.**

**Их Эзэн бидэнд маш их хайртай бөгөөд яг л наалдсан хоёр зүрх шиг бидэнтэй хамт байдаг.**

**Баяртай болон гунигтай зүрхээ гэртээ авч яваад хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Иосефын шоронд байсан тухай, бас тэр хэрхэн Их Эзэнд итгэж байсан тухай ярьж өгөөрэй. Захиас үгээ сүүлийн удаа хамтдаа хэлцгээе.**



Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.

#### Хэрэгтэй зүйлс:

- баяртай болон гунигтай зүрхний загвар (х.147)
- цаас
- өнгийн харандаа
- модон савх
- цавуу

#### Хичээлийн Хаалт

Нэг хүүхдийг залбирахад нь урамшуулаарай. Хүн бүрт долоо хоногоо сайхан өнгөрөөхийг нь ерөөгөөд Их Эзэн тэдэнд үргэлж хайртай байдаг гэдгийг нь сануулаарай.



## Иосеф Шоронд Орсон нь

### Унших Зүйл

Эхлэл 39:1-6, 17-23; 40:1-23; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 213-219.

### Цээжлэх Ишлэл

"Их Эзэн Есүс Христийн хайраас биднийг юу ч салгаж үл чадна" (Ром 8:38, 39).

### Гол Санаа

**Их Эзэн ямар ч үед бидэнтэй хамт байдаг.**

*Чамд тохиолдсон хамгийн сайн явдлын тухай санаж байна уу? Харин хамгийн муу зүйл нь бас юу вэ? Их Эзэн Иосефтой хамт байсан шигээ муу эсвэл сайн цагуудад тантай ч хамт байдаг гэдгийг та мэддэг үү?*

Иосеф итгэж ядан байлаа. Өчигдөрхөн л тэрээр эзнийхээ гэрийн бүхий л асуудлыг хариуцдаг байлаа. Харин өнөөдөр эзэн нь түүнийг шоронд хийсэн.

Иосеф ямар ч буруу зүйл хийгээгүй гэдгээ мэдэж байлаа. Тэрээр үүнээс ч илүү чухал зүйл болох түүнийг хаана ч байсан Бурхан Эзэн хамгаалж хамт байх болно гэдгийг мэдэж байсан юм. Шоронгийн ахлах хуяг Иосефт хийх ажил өглөө. Иосеф ямар ч гомдол гаргахгүй ажиллаж байв. Өгсөн ажлыг нь өдөр бүр маш сайн хийж байгааг хуяг харж байсан юм. Тэгээд удалгүй Иосефыг шоронгийн бусад хоригдлуудыг харгалзаж байх үүрэг өгчээ.

Нэгэн өглөө хоёр хоригдол ихэд сэтгэл нь зовсон байхыг Иосеф анзаарчээ. Нэг нь хааны дарс аягалагч, нөгөө нь хааны талхчин байв. Хаан тэдэнд ихэд уурласан тул тэд шоронд оржээ.

"Юу болоо вэ" гэж Иосеф асуулаа. "Бид өчигдөр их л сонин зүүд зүүдэллээ. Тэгээд ямар учиртайг нь бид мэдэхгүй байнаа" гэж хааны дарс аягалагч толгойгоо маажингаа хэлэв.

"Зүүдийг тайлагч нь Эзэн Бурхан билээ" гэж Иосеф хэлээд "Надад зүүдээ хэлээч" гэв.

"Би гурван мөчиртэй усан үзмийн мод зүүдэллээ. Мөчир бүрт нь усан үзэм байх бөгөөд би

усан үзмийн шүүсийг шахаж хааны онцгой аяганд хундагалан өгч байх юм" хэмээн дарс аягалагч хэлэв.

"Бурхан Эзэн зүүдийг чинь тайлбарлах болно. Гурван өдрийн дараа хаан чамайг суллах болно. Тэгээд чи өөрийн хуучин ажлаа хийх болно. Ордондоо очоод хаантай уулзаад миний тухай хэлж өгөөрэй" гэж Иосеф хэлэв. "Би ямар ч буруу зүйл хийгээгүй билээ. Би шоронд орох ёсгүй хүн байсан юм" гэж хэлэв.


Ингээд талхчин: "Миний толгой дээр 3 сагс талх байх юм. Тэр их гоё талх, бялуунууд байсан. Бүгдийг нь хаанд зориулж хийсэн. Гэтэл шувууд ирээд түүнийг маань идчихлээ" гэж зүүдэллээ гэв.

Иосеф намуухан дотроо залбираад "Би таны зүүдийг тайлж өгье" гэж аяархан хэлэв. "Гурван өдрийн дараа хаан чамайг шийтгэж толгойг чинь авах болно" гэв.

Гурван өдрийн дараа хааны төрсөн өдөр болж их том найр хийв. Энэ баярын үеэр хаан дарс аягалагч болон талхчингаа шоронгоос авчруулжээ. Тэгээд Иосефын хэлсэнчилэн дарс аягалагч хуучин ажилдаа орж, талхчин шийтгэл хүлээжээ.

Иосеф дарс аягалагч өөрийнх нь тухай хаанд хэлэх байх гэж хүлээсээр л байлаа. Харин дарс аягалагч Иосефыг мартсан байлаа.

Дарс аягалагч өөрийг нь мартсанд Иосеф гунигтай байлаа. Гэхдээ Бурхан Эзэн өөрт нь хайртай гэдгийг тэр мэдэж байлаа. Шоронд байсан ч өөрийг нь Бурхан анхаарч халамжилна гэдэгт Иосеф итгэж байсан юм.



# Дасгал Ажил



## Шаббат

Энэ долоо хоногийн турш өдөр бүр Библийн түүхээ уншиж, цээжилсэн ишлэлээ хамтдаа давтаарай.

**Их Эзэн Есүс** .....Дээшээ заах.

**Христийн**

**хайраас** .....Цээжин дээрээ гараа зөрүүлж тавих.

**биднийг** .....Өөрийгөө заах.

**юу ч** .....Долоовор хуруугаа үгүй гэсэн маягтай хөдөлгөх.

**салгаж үл чадна.** .....Гараа нийлүүлээд хоёр тийш нь салгах.

**Ром 8:38,39** .....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## Ням

Хүүхэдтэйгээ хамт талх эсвэл жигнэмэг хийгээрэй. Бусдад хоол эсвэл шүүс хийж өгдөг хүмүүст итгэх хэрэгтэй талаар ярилц.

Оройн хоолны үеэр хүүхэд тань талхчин эсвэл цай аягалагчийн дүрд тоглож үйлчилж болно.

## Даваа

Шаббат хичээл дээр хийсэн баяртай болон гунигтай нүүрээ хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Иосефын шоронд байсан тухай ярьж өгөхөд нь урамшуулаарай.

Хүүхдийнхээ толгой дээр ном тавиад тэнцвэртэйгээр өрөөн дундуур алхуул. Номыг хэр удаан байлгаж байгаад унагасан бэ? Асуух нь: Энэ хэцүү байна уу? Амархан байна уу? Ямар ч үед Их Эзэн чамтай хамт байдаг гэдгийг сана.



## Мягмар

Самар, будаа,

гоймон зэргийг ашиглаад аяга чимэглэхэд нь хүүхдэдээ туслаарай. Тэр аягандаа хүүхэд тань ус эсвэл шүүс хийж болно.



## Лхагва

Шүдний эмчид үзүүлэх, тариа хийлгэх зэрэг чухал боловч хүүхдийнхээ дургүй зүйлийн тухай сана. Хүүхэдтэйгээ ээлжлэн эдгээр үйл явдлуудыг жүжиглэж нэг нь таах болно. Ямар ч үед Их Эзэн биднийг хайрлаж байдгийнх нь төлөө Түүнд талархаарай.

## Пүрэв

Дараах мөргийг давтаарай. Их Эзэн намайг баяртай байхад хайрлаж л байдаг. Намайг гунигтай байхад хайрлаж л байдаг. Их Эзэн бүх зүйл муу байхад намайг хайрлаж байдаг. Бүх зүйл сайн байхад ч хайрлаж байдаг.

"Их Эзэн хамгийн сайн нь" гэдэг дууг дуул.

Ямар ч үед та нартай хамт байж таныг болон таны хүүхдийг халамжилж байдагт нь Их Эзэнд талархаарай.

## Баасан

Гэр бүлтэйгээ хамтран Библийн түүхийг жүжиглээрэй. Асуух нь: Иосефыг сайн хүн байсан гэдгийг нь чи яаж мэдэж байна вэ? Сайн болон муу цаг үеийн тухай ярилц. Ямар ч үед хамт байдагт нь Есүст таларх.